



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/27

Хужирт сум


Агаарын бохирдолын эх үүсвэрийн
2021 оны тооллогын ажлыг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 (г), Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.14, 8.1.5, 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2018 оны “Журам батлах тухай” А/479 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлын эх үүсвэрийн 2021 оны ээлжит тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.


2. Ээлжит тооллогын бэлтгэл ажлыг ханган, тооллогыг 2021 оны 2 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд чанартай зохион байгуулж, тооллогоор нөхөгдсөн асуулгын хуудас, эх үүсвэрийн мэдээллийг тооллогын мэдээллийн санд байршуулж, бусад материал зэргийг тогтоосон хугацаанд аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний албанд хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Дэмбэрэл), Нарийн бичгийн дарга (Б.Бямбасүрэн), Багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2021 оны 02 дүгээр
сарын 22 -ны өдрийн 7/27 дугаар
захирамжийн хавсралт



Сумын ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Б.Дэмбэрэл - Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Б.Бямбасүрэн - Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Гишүүд: Ч.Сонинбаяр-Байгаль хамгаалагч

Б.Дуламжав-Байгаль хамгаалагч

Б.Пүрэвжав-Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Ц.Нямдорж-Газрын даамал

Б.Пагамдулам-1 дүгээр багийн Засаг дарга

Д.Батбаян – 2 дугаар багийн Засаг дарга

Д.Галиндэв-3 дугаар багийн Засаг дарга

Д.Батбаяр-4 дүгээр багийн Засаг дарга

Ц.Лхамролом –5 дугаар багийн Засаг дарга

Ц.Амгалан-6 дугаар багийн Засаг дарга

-oOo-

250100054